



ХОРИХ 417-Р АНГИ

2013 оны Санхүүгийн Тайлан

Төв аймгийн Аудитын газар нь Төрийн Аудитын тухай хуульд заасан Аймгийн Аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд улсын болон орон нутгийн төсвөөс санхүүждэг төсөвт байгууллагын санхүүгийн тайланд нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим холбогдох хууль, журам зааварт нийцүүлэн аудит хийж байна.

Аудитыг дуусгавар болгосон тухай тайлан

АГУУЛГА

ХУУДАС

Лавлах зүйлс байвал доорх хаягаар холбоо барина уу:

Аймгийн Ерөнхий Аудитор

Л.Жаргалсайхан

Утас: 70272287

[И-мэйл](#)

Аудитын менежер:

Т.Майцэцэг

Утас: 70273465

СТАудитын багийн: Шинжээч

Ц.Хишигжаргал

Утас: 70273204

И-мэйл: khj_616@yahoo.com

ТӨАГ-ын хаяг:

Төв аймаг Зуунмод сум 1-р баг

Төрийн байгууллагуудын ордон

• Танилцуулга	4
• Санхүүгийн дотоод хяналт	4-7
• Гол шийдлүүд	8
• Залруулаагүй алдаа	8
• Тайлбар мэдүүлгийн захидал.....	9
• Аудитын санал дүгнэлт	9

ХОРИХ 417-Р АНГИ-ЫН 2013 ОНЫ Санхүүгийн тайланд

ААГазар аудит хийж дууссан тухай мэдэгдэл

Бид Хорих 417-р ангийн 2013 оны Санхүүгийн тайланд аудитаа хийж дуусаж байна. Хорих 417-р ангийн төсвийн Ерөнхий менежерт энэхүү аудит хийж дуусгах тухай мэдэгдлийг өргөн барьж улмаар энэхүү санхүүгийн тайланг дахин шалган нягталж бидэнд туслахыг хүсч байна. Удирдлагын захидал хэмээх тусдаа хэсэгт санхүүгийн хяналтыг сайжруулах талаарх бидний өгсөн зөвлөмжүүд орсон бөгөөд Хорих 417-р анги нь тухайн зөвлөмж бүрд хариу явуулна уу.

Удирлагын зөвлөлийн анхаарлыг дараах зүйлд чиглүүлж байна:

- Гол санхүүгийн хяналтууд хамрагдсаныг **тодруулбал:**

Байгууллагын үйл ажиллагааны санхүүгийн тайланд аудит хийлээ.

НББ-ийн үе шат бүрд дээд шатны түвшний удирдлага хүрдэг эсэх, нийтлэг чанартай зардал, төсвийн санхүүжилт, өөрийн орлого, цалингийн зардал, өглөг, авлага, балансын үзүүлэлтүүд, үндсэн хөрөнгө, бараа материал, бусад асуудлуудыг хамруулсан бөгөөд байж болзошгүй эрсдлийг тооцож холбогдох батламж мэдэгдлүүд хэрхэн хангагдаж байгааг нотлох үүднээс холбогдох стандарт, журам зааврын дагуу шаардлагатай горимыг хэрэгжүүлсэн.

Гол илрүүлсэн зүйлс аудитын үр дүнгээс гарсныг **тодруулбал:**

- Үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны орлогыг бодитой төлөвлөөгүй, орлогод бүртгэлээр тавих хяналтыг сайжруулж, үндсэн үйл ажиллагааны орлогыг дансанд зөв бүртгэн тусгах шаардлагатай байна.
- Кассанд нэг удаагийн татан авалтаар авч зарцуулсан мөнгөний хэмжээ зөвшөөрөгдөх хэмжээнээс их байгаа нь Сангийн сайдын 2012 оны 12-р сарын 21 ны өдрийн 276 тоот тушаалаар батлагдсан “Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам”-ыг зөрчсөн байна.
- Тухайн жилийн хоригдол ажиллуулсаны орлого 25673.1 мянган төгрөгөөс ХАОАТатвар 10%-иар тооцож 2567.3 мянган төгрөгийн татварыг нөхөн төлөх шаардлагатай байна. Иймд ажлын хөлснөөс тооцож төлөөгүй татвар болох 2567.3 мянган төгрөгийг тус байгууллагаар төлүүлэн аймгийн төсөвт оруулах төлбөрийн акт бичив.
- Харилцахын үлдэгдэл 4000.0 мянган төгрөгийг дээд газарт татан төвлөрүүлээгүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 7.7-д “төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд төсвийн захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ ” гэснийг зөрчиж байгаа тул дээрх мөнгийг аймгийн төсөвт оруулах төлбөрийн акт бичив.

Аудитыг дуусгаж аудитын явцад олж авсан ажлын баримтанд үндэслэн нийт зөрчлийн хэмжээгээр агуулгаараа урьдчилан тогтоосон материаллагын түвшингээс их байгаа учир **зөрчилгүй санал дүгнэлт** гаргахаар Ерөнхий аудиторт санал оруулсан.

- Тэргүүлэх Аудитор 2014.02.24-ний өдөр санал дүгнэлтэнд гарын үсэг зурна.

Эцэст нь аудитын явцад Ахлах нягтлан бодогч Б.Ванчинхүү болон бидэнтэй хамтран ажилласан ажилтнуудад гүнээ талархаж байна.

Аймгийн Аудитын газар

2014.02.23

Танилцуулга

1. Бид Хорих 417-р ангийн 2013 оны 12 дугаар сарын 31-р тасалбар болсон санхүүгийн тайланд аудитаа хийж дуусаж байна. Хорих 417-р ангийн даргад энэхүү аудит хийж дуусгах тухай мэдэгдлийг өргөн барьж улмаар санхүүгийн тайланг дахин шалган нягталж бидэнд туслахыг хүсч байна. Удирдлагын захидал хэмээх тусдаа хэсэгт санхүүгийн хяналтыг сайжруулах талаар бидний өгсөн зөвлөмжүүд орсон бөгөөд Хорих 417-р ангийн удирдлага нь тухайн зөвлөмж бүрд хариу явуулна уу.

2. Бидний 2013 оны тайланд хийсэн аудит нь 2 гол элементтэй:

- Санхүүгийн хяналтын системийг дахин шалгах;
- Жилийн санхүүгийн тайланд аудит хийх.

Аудитаас үүдэн гарсан асуудлууд дараах хэсэгт хураангуйлагдсан.

Жилийн санхүүгийн тайланд аудит хийх

1. Аймгийн Аудитын Газар нь 2013 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг баталгаажуулах шаардлагатайг авч үзсэн. Бидний дахин шалгалтын үр дүнд цаг ямагт үр өгөөжтэй байж, материаллаг алдаанаас сэргийлж чадах гол санхүүгийн хяналтыг онцгойлон үзсэн юм.

2. Дараах 8-н түвшний хяналтын асуудал бидний дахин шалгалтын үр дүнгээс гарсан бөгөөд үүнд Хорих 417-р ангийн удирдлагын анхаарлыг хандуулж байна:

1. Орлого, санхүүжилтийн талаар

- Мөнгөн гүйлгээний тайлангийн орлого, урсгал санхүүжилт 572758.3 мянган төгрөг, үндсэн бус үйл ажиллагааны орлого буюу эргэлт уулзалтын орлого 1517 мянган төгрөг, бараа үйлчилгээний орлогод хоригдол ажиллуулсаны орлого 25673.1 мянган төгрөг, мал аж ахуйн орлого 16140.4 мянган төгрөг ялтаны нэрийн дансны орлого 34572.9 мянган төгрөг нийт 123355.3 мянган төгрөг тус тус орсон байна. Төсвийн гүйцэтгэлийн тайланд зардлыг төсвөөс санхүүжүүлэх 572758.3 мянган төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоос 16140.4 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлого 46968.8 мянган төгрөг бусад орлого 27190.1 мянган төгрөг нийт 663057.5 мянган төгрөгөөр тайлагнасан байна.
- ШШГЕГазраас Хорих 417-р ангийн 2013 оны урсгал зардлын төсвийг 573057.8 мянган төгрөгөөр төсвөөс санхүүжих, 46500.0 мянган төгрөгийн үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжихээр нийт 619557.8 мянган төгрөгөөр баталж сар бүрийн төсвийн хуваарийг гаргасан байна. Тайлант оны гүйцэтгэлээр 663057.5 мянган төгрөг буюу батлагдсан төлөвлөгөөнөөс 43499.7 мянган төгрөгөөр илүү санхүүжсэн байна.
- Үндсэн бус үйл ажиллагааны орлого 46500.0 мянган төгрөгөөр батлагдсаныг гүйцэтгэлээр 90299.3 мянган төгрөг оруулж 43799.3 мянган төгрөгөөр давуулсан байна. Бараа үйлчилгээний урсгал зардалд 619557.8 мянган төгрөг батлагдсанаас гүйцэтгэлээр 618389.6 мянган төгрөгийн зарцуулж 1168.1 мянган төгрөгөөр хэмнэж ажилласан байна.
- Туслах үйл ажиллагаанаас орох орлогыг бодитой төлөвлөөгүй, орлогод бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах шаардлагатай байна.

2. Мөнгөн хөрөнгө

- Төрийн сан дахь харилцах дансаар болон байгууллагын мөнгөн кассаар нийт 697630.5 мянган төгрөгийн санхүүжилт, болон бусад орлогыг төвлөрүүлж үйл ажиллагааны холбогдох зардал, ялтны ажлын хөлс зэрэгт 668197.9 мянган төгрөгийг зарцуулан 32355.5 мянган төгрөг үлдсэнээс ялтны нэрийн дансанд 26282.9 мянган төгрөг нь төрийн сангийн харилцах дансанд 4000.0 мянган төгрөг, байгууллагын кассанд 2072.5 мянган төгрөг үлдсэн гэж тайлагнасан байна.
- Харилцахын үлдэгдэл 4000.0 мянган төгрөгийг дээд газарт татан төвлөрүүлээгүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 7.7-д “төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд төсвийн захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ” гэснийг зөрчиж байгаа тул дээрх мөнгийг аймгийн төсөвт оруулах төлбөрийн акт бичив.
- Харилцах дансны гүйлгээг шалгахад чекээр болон бусад орлогын мөнгө 169743.3 мянган төгрөгийг кассанд бэлнээр авч, албан хаагчдын цалин, хоригдлуудын ажлын хөлс болон бусад үйл ажиллагааны зардлуудад зарцуулсан байна. Кассанд нэг удаа татан авч зарцуулсан мөнгөний хэмжээ нь зөвшөөрөгдөх хэмжээнээс их байгаа нь Сангийн сайдын 2012 оны 12-р сарын 21 ны өдрийн 276 тоот тушаалаар батлагдсан “Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам”-ыг зөрчсөн байна.

3. Цалингийн талаар

- Цалингийн программ ашигладаггүй ба 1-12 сарын цалингийн цэсийг нэгтгэн шалгахад нийт 381443.5 мянган төгрөгийг олгохоор тооцож, ХАОАТатварт 32571.2 мянган төгрөг ЭМДаатгалд 7593.3 мянган төгрөг, бусад суутгалд 1870.7 мянган төгрөг нийт 42035.2 мянган төгрөгийг зохих журмын дагуу суутган ажилчдын цалингийн картанд нийт 339637.5 мянган төгрөг шилжүүлсэн байна.
- Ажилчдыг батлагдсан орон тоогоор ажиллуулж байгууллагын үүрэг гүйцэтгэх чадамжыг бүрэн хангаж ажиллах, гүйцэтгэсэн ажил үүргийг тодорхой дурдаж урамшуулалыг олгож байх.
- Цалингийн карт хөтөлсөн байдлыг шалгахад хүн тус бүрт карт хөтөлдөггүй, харин цалингийн цэсэнд гарын үсэг бүрэн зуруулсан байна. Нийт орон тоо 44, дарга 2, гүйцэтгэх ажилтан 42 хүний бүрэлдэхүүн ажилласан байна. 2012 оны Засгийн газрын 78-р тогтоолын дагуу албан хаагчдын цалингийн шатлал, сүлжээний дагуу цалинг зөв тогтоосон байна.
- Цалингийн программ ашиглан цалинг бодож байх.

4. Бараа үйлчилгээний зардал

- Бараа үйлчилгээний зардал нь батлагдсан төлөвлөгөөгөөр 192257.8 мянган төгрөг, үр дүнгийн тайлангаар 227418.5 мянган төгрөг буюу батлагдсан төлөвлөгөөнөөс 35160.7 мянган төгрөг хэтэрсэн байна. Төсвийн гүйцэтгэлийн тайлангаар Бараа, үйлчилгээний зардал нь 191621.7 мянган төгрөгөөр тайлагнагдсан 636.1 мянган төгрөгөөр хэмнэгдсэн гэж тусгасан байна.
- Бараа үйлчилгээний нийт зардал нь хэмнэгдсэн мэт харагдаж байгаа боловч зардал хооронд буюу хоолны зардлаас 3856.7 мянган төгрөг, төлбөр

хураамжын зардлаас 5350.0 мянган төгрөг, төрийн нэрийн өмнөөс гүйцэтгэсэн ажил үйлчилгээний зардал 6195.0 мянган төгрөг, түлш халаалтаас 2028.7 мянган төгрөг, гэрэл цахилгаанаас 2532.6 мянган төгрөг гэх мэт нийт 19963.0 мянган төгрөгийг үйлдвэрлэлийн болон урсгал заварын зардалд гүйлгэн зарцуулсан байна. Мөн 8000.0 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлэн зарцуулсан байна.

- Мөнгөн гүйлгээний тайлангаар хүнсний материалын зардалд 89817.1 мянган төгрөг зарцуулсаныг sort/filter ашиглан шалгахад 8419.8 мянган төгрөгийн үнэ бүхий шатахуун, сэлбэг, компьютер, тоног төхөөрөмж гэх мэт зүйлсийг тус зардалд оруулан тайлагнасан байна. Тээвэр шатахууны зардалд 18800.0 мянган төгрөг батлагдаж 19063.1 мянган төгрөг зарцуулсан ба 263.1 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан байна.
- Урсгал засварын зардалд 9800.0 мянган төгрөг батлагдсан боловч 14136.5 мянган төгрөг зарцуулж 4336.5 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан байна. Ингэхдээ дээрх барилгын засварын материалуудыг бараа материалын дансаар дамжуулалгүй зардалд шууд тусгасан байна. Барилгын засварт 14136.5 мянган төгрөгийн материал зарцуулсан ба урсгал засвар хийх тухай гэмтлийн акт тогтоож шаардагдах материалыг тооцож төсөвлөөгүй байна.
- Сэлбэг хэрэгсэлийн зардалд 2773.2 мянган төгрөг бараа материалын дансаар дамжин зарцуулсан боловч урсгал засварын зардалд тусгаагүй, өндөр үнэтэй сэлбэг хэрэгсэл засвар үйлчилгээ хийлгээд уг хөрөнгийг/автомашиныг/ капиталжуулж данс бүртгэлд тусгаагүй, автомашинд засвар үйлчилгээ сэлбэг хэрэгсэл авч тавих талаар техникийн комиссын тогтоосон акт байхгүй, буруутай этгээдийг тогтоож хариуцлага тооцдоггүй байна. Мөнгөн хөрөнгийн болон бараа материалын орлого, зарлагын журнал, ТС-гийн хуулга, ЕД, ЕЖ, өглөг авлагын дэлгэрэнгүй журнал, АШБаримтыг ашиглан шалгав.
- Санхүүгийн тайлангаар бараа үйлчилгээний урсгал зардал нийт дүнгээрээ хэтрэлттэй, зардлын хооронд гүйлгэн зарцуулсан байна. Төсвийн төлөвлөлтийг бодитой хийж зардал хооронд нь гүйлгэн зарцуулахгүй байхад анхаарч ажиллах

5. Үндсэн хөрөнгө

- Санхүүгийн байдлын тайлангийн хөрөнгийн эхний үлдэгдэл 659665.9 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 657745.8 мянган төгрөгийг үндсэн хөрөнгийн тодруулгын тайлангийн үлдэгдэлтэй тулгахад тохирч байна. Тайлант онд 4609.8 мянган төгрөгийн тоног төхөөрөмж шилжин ирж үндсэн хөрөнгийн дүн нэмэгдсэн ба авто тээврийн хэрэгсэл 6530.0 мянган төгрөгийн хөрөнгө атлагдсан байна. Дээрх хөрөнгүүдийг актлахдаа ШШГЕГазраас зөвшөөрөл авсан байна. Хөрөнгийн үлдэгдлийг жилийн эцсэст тооллого хийсэн бүртгэлтэй тулган шалгахад тооллогын бүртгэл болон тооцоо бодсон тухай комисс гарын үсэг зурж албажуулсан байна.
- Тус байгууллага нь жилийн эцсийн тооллогыг байгууллагын даргын 2013 оны 12 сарын 16-ны өдрийн А/52 тоот тушаалаар тооллогын комиссыг томилж үндсэн хөрөнгийн тооллогыг хийсэн байна. ШШГЕГазрын шийдвэрээр үндсэн хөрөнгийг актласан байна.

6. Бараа материал

- Санхүүгийн байдлын тайлангаарх бараа материалын эхний болон эцсийн үлдэгдэлийн дүнг, Бараа материалын тодруулгын тайлангийн дүнтэй тулгахад тус бүр тохирч байна. Бараа материалын тодруулгын тайлангийн төсвийн хөрөнгөөр 161348.5 мянган төгрөгийн, үнэ төлбөргүй авсан 8129.6 мянган төгрөгийн, бусад өөрийн орлого буюу туслах аж ахуйгаас 24277.3 мянган төгрөгийн буюу нийт 193755.4 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна. Мөн тайлант онд бараа материалын данснаас зарцуулсан 151351.8 мянган төгрөг, худалдсан 20687.5 мянган төгрөг, актлагдсан 412.0 мянган төгрөг, шилжүүлсэн 3158.0 мянган төгрөг нийт 175609.4 мянган төгрөгөөр хасагдсан байна.
- Тус байгууллага нь шатахууны зардалд 19063.1 мянган төгрөг зарцуулсан ба гүйцэтгэсэн ажлыг шалгахад батлагдсан маршрут байхгүй, замын хуудас бичиж шатахуун зарцуулалтанд хяналт тавидаггүй, жолоочийн тооцоог боддоггүй, ажил гүйцэтгэсэн тухай хянаж баталгаажуулсан анхан шатны баримтууд байхгүй байна.
- Эм тарианы зардалд 3500.0 сая төгрөг төсвөлсөнөөс 3528.5 мянган төгрөг зарцуулсан ба Моносфарм ХХК-нд шилжүүлсэн эмийн үнийг зардалд шууд тусгасан байна. Бараа материалын данс дахь эмийн зарцуулалтыг нэр төрлөөр нь шалгахад эм нэг бүрээр нь данс бүртгэлд тусгаж зарцуулсан байна. Тооллогын бүртгэл дээр эмийг нэг бүрчлэн бичиж тусгасан байна.
- Хүнсний материалын зардалд 93673.8 мянган төгрөг төсөвлөсөн ба мөнгөн гүйлгээний тайлангаар 89817.0 мянган төгрөг зарцуулсан гэж тайлагнасан байна. Хоолны зардалд 8419.8 мянган төгрөгийн урсгал засварын материал болон тоног төхөөрмжийн үнэ оруулж тусгасан буюу шууд зардал болгосон гэж харагдаж байна. Үүнийг няравын тайлантай тулган үзэхэд бараа материалын тайлан гаргаж зарцуулсан нь тогтоогдлоо.
- Тус байгууллага нь туслах аж ахуйдаа нийт 1006 толгой буюу 33598.0 мянган төгрөгийн малтай бөгөөд малын төрөл, нас хүйсээр нь ялгаж данс бүртгэлд зөв тусгасан байна. Тайлант онд ТАА-аас 16140.0 мянган төгрөгийн бодит орлого оруулсан байна. Бараа материалыг дансанд тусгахдаа зөв ангилан бүртгээгүй, хуулийн хугацаанд тооллого хийж, тооцоо бодсон гэх боловч үр дүн муутай болсон байна.

7. Авлага ,өглөгийн талаар

- Хорих 417-р анги нь 2013 оны эхэнд 1344.0 мянган төгрөгийн авлагатай, 2922.9 мянган төгрөгийн өглөгтэй гэж тайланд тусгасан байна. Авлага, өглөгийг журналаас тулган үзэхэд байгууллага хувь хүмүүстэй 104676.0 мянган төгрөгийн авлага үүсгэж 104887.5 мянган төгрөгийг барагдуулсан 1132.5 мянган төгрөгийн авлагатай байна. Мөн тайлант онд ажилчин албан хаагчдын болон ялтаны цалин, НДШ, ХАОАТатаврт нийт 434481.4 мянган төгрөгийн өглөг тооцоолж барагдуулсан ба хоригдолын цалинд /нэрийн дансанд/ 26282.9 мянган төгрөгийн өглөгтэй байна.
- Тайлант онд хоригдол ажиллуулсаны орлого нийт 25673.1 мянган төгрөг орсон бөгөөд уг ажлын хөлснөөс ХАОАТатварыг суутгаж улсын төсөвт шилжүүлэх ёстой байна. Дээрх татварыг тухай байгууллага нь тооцон авч татварын

хэлтэсийн дансанд шилжүүлээгүй байна. Зүй нь гэрээт байгууллагуудаас ажлын хөлс орж ирмэгц дүнгээс 10%-иар тооцож татварын хэлтэст шилжүүлэх ёстой байжээ. Иймд тухайн жилийн хоригдол ажиллуулсаны орлого 25673.1 мянган төгрөгөөс ХАОАТатвар 10%-иар тооцож 2567.3 мянган төгрөгийн татварыг нөхөн төлөх шаардлагатай байна.

Иймд ажлын хөлснөөс тооцож төлөөгүй татвар болох 2567.3 мянган төгрөгийг тус байгууллагаар төлүүлэн аймгийн төсөвт оруулах төлбөрийн акт бичив.

8. Дотоод хяналт шалгалт

- МУ-ын ЗГазрын 2011.11.09-ний өдрийн 311-р тогтоолоор аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам батлагдсан байна. Энэхүү журмын 1.4-т зааснаас бусад тохиолдолд “Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам” -ыг тухайн байгууллага, аж ахуйн нэгж өөрөө баталж мөрдөнө гэж заасны дагуу дотоод хяналтын алба томилож ажиллаагүй байна.
- ШШГЕГазрын даргын 2013 оны 6-р сарын 19-ны өдрийн б/826 тоот тушаалаар тус албаны хэмжээнд “дотоод хяналт шалгалт, аюулгүй байдал, хяналт шинжилгээ, үнэлгээ”-г хариуцсан ажилтаныг томилон ажиллуулах шийдвэр хэрэгжээгүй байна. байна.

Бидний дахин шалгалтын үр дүнд дээр дурдсан 8 хэсгүүдийн дотоод хяналтын ситем нь тухайн жилд хангалттай байсан ба нягтлан бодох бүртгэл нь Санхүүгийн тайлангийн зохистой үндэс болсон нь ажиглагдсан юм. Сайжруулах шаардлагатай байж болох хэд хэдэн санхүүгийн хяналтын талаар хавсралт бүхий удирдлагын захидалд тусгасан болно.

Аудитын явцад хийгдсэн гол шийдлүүд

5. Дараах хэсэгт Санхүүгийн тайлангийн аудитын явцад гарсан гол асуудлуудыг хураангуйлан тэмдэглэсэн.

- ✓ Байгууллагын батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж, гүйцэтгэлийг зөв тайлагнаж байх
- ✓ Төсвийн төлөвлөлтийг бодитой хийж зардал хооронд нь гүйлгэн зарцуулахгүй байх
- ✓ Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журмыг мөрдөх

Бидний илрүүлсэн зүйлс болон дээрх санхүүгийн дотоод хяналтын талаар санал нь удирдлагын захидалд тусгагдсан байна. Санхүүгийн гүйлгээнүүд нь хүлээн зөвшөөрхүйц зохицуулагдсаныг тэмдэглэсэн.

Залруулагдаагүй алдаа

Аудитын стандарт нь аудитын явцад илэрсэн тодорхой биш болон залруулагдаагүй алдаанд анхаарал тавихыг шаарддаг. Эдгээр залруулагдаагүй алдаанууд байгууллагын удирдлагын анхаарлын төвд хүргэгдэх болно. Аудитын явцад орлогын болон зардлын дансуудыг харьцуулан бичилт хийсэн мянган төгрөгийн алдааг залруулсан болно. Бусад алдааг залруулаагүй болно

Тайлбар мэдүүлгийн захидал

7. Аудитын үйл явцад аймгийн Аудитын газар хөндлөнгийн аудиторын хувьд удирдлагын зүгээс гаргасан баталгаанд тулгуурлах ёстой байсан ч хараат бус байдлын хувьд энэ батламжийг дагах нь зохистой байсангүй. Аудитын гүйцэтгэл бүрд /тайлбар мэдүүлгийн захидлаар/ санхүү бүртгэлийн даргаас эдгээр батлагааг бичгээр баталгаажуулан олж авахыг хүсч байна.

Өмнөх зөвлөмжийн биелэлт

Өмнөх жилүүдэд тухайн байгууллагад санхүүгийн тайлангийн аудит хийгдэж байгаагүй ба ШШГЕГазрын дотоод аудит нь байгууллагуудад түүвэрлэн шалгалт хийсэн байна.

Аудитын санал дүгнэлт

Аймгийн аудитын газраас тус тайланд гарсан алдаа нь урдчилан тооцсон материаллагын түвшинд хүрээгүй тул **зөрчилгүй санал дүгнэлт** гаргахаар санал оруулж байна.

Аймгийн Аудитын газар.